



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ц.МӨНХТУЯА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.cabinet.gov.mn

дсЛБ. 09. 03 № ХТ/2997
танай _____-ны № _____-т

**Асуулгын хариу хүргүүлэх
тухай**

Танаас 2026 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 45 дугаартай албан бичгээр Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд багшийн цалинг нэмэгдүүлэх талаар дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Боловсролын яамнаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу хүргүүлж байна.

Асуулга 1-ийн хариулт:

"Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2026 оны 151 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн цэцэрлэг, сургуулийн багш ажилтны албан тушаалын цалинг 50 хувиар нэмэгдүүлэн тогтоосон.

Багш нарын цалин олголтод дутагдаж буй эх үүсвэр болох 674.9 тэрбум (2026 оны 05 дугаар сараас боловсролын салбарын багш, ажилтны албан тушаалын цалинг 50% нэмэгдүүлсэн дүнгээс "нэмэгдэл"-ийг тооцож олгож эхэлсэнтэй холбоотой үүссэн зөрүү дүн) төгрөгийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Асуулга 2-ын хариулт:

Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудаст мэдээлснээр улсын дундаж нэрлэсэн цалин 3,205.600 төгрөг байгаа бөгөөд цаашид салбарын багш, ажилтны үндсэн цалинг үе шаттай нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Засгийн газраас төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, хөлсийг 10 хувь нэмэгдүүлэхтэй холбоотой тооцоо, судалгааг хийж, шаардагдах хөрөнгийг Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

000265008757

Цэцэрлэгийн багшийн дундаж цалин 2026 оны 05 дугаар сарын байдлаар **4,056.6** төгрөг (тооцсон цалингаар) олгож байна (хүснэгтээр задаргааг харууллаа):

2,000,000.00 төгрөгөөс доош цалин авч буй багш нарын эзлэх хувь	1.6%
2,000,000.00-2,500,000.00 төгрөгийн цалин авч буй багш нарын эзлэх хувь	1.2%
2,500,000.00-3,000,000.00 төгрөгийн цалин авч буй багш нарын эзлэх хувь	6.2%
3,000,000.00-3,500,000.00 төгрөгийн цалин авч буй багш нарын эзлэх хувь	13.9%
3,500,000.00-аас дээш төгрөгийн цалин авч буй багш нарын эзлэх хувь	77.0%

Ерөнхий боловсролын сургуулийн багшийн дундаж цалин 2026 оны 05 дугаар сарын байдлаар **3,917.2** төгрөг (тооцсон цалингаар) олгож байна (хүснэгтээр задаргааг харууллаа):

2,000,000.00 төгрөгөөс доош цалин авч буй багш нарын эзлэх хувь	1.3%
2,000,000.00-2,500,000.00 төгрөгийн цалин авч буй багш нарын эзлэх хувь	1.9%
2,500,000.00-3,000,000.00 төгрөгийн цалин авч буй багш нарын эзлэх хувь	8.9%
3,000,000.00-3,500,000.00 төгрөгийн цалин авч буй багш нарын эзлэх хувь	19.9%
3,500,000.00-аас дээш төгрөгийн цалин авч буй багш нарын эзлэх хувь	67.9%

Асуулга 3-ын хариулт:

Засгийн газрын 2026 оны 151 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосны дагуу хэрэгжилтийг бүрэн хангах хүрээнд Боловсролын сайдын 2026 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан зохицуулалт хийх замаар шийдвэрлэж байна.

Засгийн газраас боловсролын салбарын багш, ажилчдын цалин хөлсний дутагдаж байгаа санхүүжилтийн эх үүсвэрийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусган, Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байгаа талаар асуулга 1-ийн хариултад тусгасан болно.

Асуулга 4-ийн хариулт:

Засгийн газраас боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалин хөлсийг салбарын хүний нөөцийн бодлого, багшийн ажлын ачаалал, гүйцэтгэлийн үнэлгээ болон хувьсах зардлын бүтэцтэй уялдуулан шинэчлэхээр ажиллаж байна.

Багшийн цалин нь хувьсах зардлын бүрэлдэхүүн бөгөөд тухайн боловсролын сургалтын байгууллагын хүүхдийн тоо, алслагдсан байдал, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж өртгөөс шалтгаалан хувьсдаг байхаар өөрчилнө.

Хувьсах зардлын шинэчлэлийн хүрээнд боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн үндсэн цалингийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх бодлого, сургалтын байгууллагын бүтэц, ажлын цагийн нормыг шинэчлэх зэрэг бодлогын арга хэмжээний нөлөөллийг тооцож 2027 оны батлагдсан хязгаарын түвшингээс **313.8** тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Мөн Монгол Улсын хүн амын тооны өсөлтийн урьдчилсан тооцоогоор 2030 он хүртэл ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн тоо жил бүр 20.0 орчим мянгаар нэмэгдэж, цаашид буурах төлөвтэй байгаа тул хүүхдийн тооны өсөлтөөс шалтгаалан гүйцэтгэлийн санхүүжилтийн хэмжээг өмнөх оны түвшингээс **98.4** орчим тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсон болно.

Асуулга 5-ын хариулт:

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан багш, ажилтны цалин хөлсийг үе шаттай нэмэгдүүлэх, нэмэгдэл хөлс, урамшууллыг тооцох аргачлалыг түүнд нийцүүлэн шинэчлэх, багшийн цалин хөлсний санхүүжилтийг хувьсах зардлын тогтолцоогоор дамжуулан төлөвлөж, санхүүжилтийн аргачлал, тооцооллыг бодит хэрэгцээ, ажлын ачаалал, үр дүнтэй уялдуулж, оновчтой, үр ашигтай болгох талаар холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран ажиллаж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ,
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХТУЯА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@moe.gov.mn,
Цахим хуудас: www.moe.gov.mn

2026.08.25 № 01/4887

танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Танаас 2026 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 45 тоот албан бичгээр ирүүлсэн "Багшийн цалинг нэмэгдүүлэх арга хэмжээний талаар" асуулгатай танилцлаа. Уг асуудалтай холбогдуулан дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2026 оны "Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 151 дүгээр тогтоолоор багш, ажилтны үндсэн цалинг 50 хувиар нэмэгдүүлсэн. Энэ шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд салбарын хэмжээнд нийт 1.1 их наяд төгрөг дутагдахаар тооцоо гарсан бөгөөд Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн цалин олголтын бодит мэдээлэлд үндэслэн цалингийн тооцооллыг хийж байна. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд салбарт дутаж байгаа цалингийн сангийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

2. Салбарын багш, ажилтны цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа бөгөөд сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын багшийн үндсэн цалинг 2.8 сая төгрөг болгон нэмэгдүүлэхэд нэг жилд 1.09 их наяд төгрөгийн санхүүжилт шаардлагатай.

3. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах явцад салбарт үүссэн цалингийн сан болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардлуудад дутагдаж байгаа эх үүсвэрийг хуулийн төсөлд тусгуулахаар Сангийн яамтай хамтран ажиллаж байна.

4. Цалин хөлсний шинэчлэлийг боловсролын салбарын хүний нөөцийн бодлого, багшийн ажлын ачаалал, гүйцэтгэлийн үнэлгээ болон хувьсах зардлын бүтцийн шинэчлэлтэй уялдуулан үе шаттай хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

5. Цалин хөлсний бодлого, тооцооллын аргачлал болон холбогдох эрх зүйн зохицуулалтыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баримталж буй бодлого, чиглэлтэй уялдуулан багш, ажилтны цалингийн бүтцийг үе шаттай сайжруулахаар ажиллаж байна. Багшийн цалин хөлсний санхүүжилтийг хувьсах зардлын тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлдэг тул уг санхүүжилтийн аргачлал, тооцооллыг бодит хэрэгцээ, ажлын ачаалал, үр дүнтэй илүү нягт уялдуулж,

1426111593

оновчтой, үр ашигтай болгох зорилгоор Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж байна.



Л.ЭНХ-АМГАЛАН